



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 339

Улаанбаатар хот

Компанийн эзэмшигчдийн өмч дэх  
төрийн өмчийн дүнг нэмэгдүүлж, дүрэмд  
өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бусад хөрөнгийн эх үүсвэрээр 2012 он, 2017 онд хийгдсэн нийт 3,632,994,400 (гурван тэрбум зургаан зуун гучин хоёр сая есөн зуун ерэн дөрвөн мянга дөрвөн зуун) төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн эзэмшигчийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 3.1 дэх заалт дахь “Компани нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 27,408,721 (хорин долоон сая дөрвөн зуун найман мянга долоон зуун хорин нэгэн) ширхэг энгийн хувьцаатай байна” гэснийг “Компани нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 63,738,665 (/жаран гурван сая долоон зуун гучин найман мянга зургаан зуун жаран таван) ширхэг хувьцаатай байна” гэж өөрчилсүгэй.

3. “Налайхын дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн өөрчлөлтийг холбогдох байгууллагад бүртгүүлэхийг компанийн гүйцэтгэх захирал Ц.Минжинхүүд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого, төлөвлөлт удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



0002085